

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Залбирал биднийг Бурханд ойртуулдаг

Далын Ахлагч Сью Хонг Пон

“Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой;” (3 Нифай 18:19). Энэ бол бидний Эзэн Есүс Христийн сургаал юм. Залбирал бол бидэнд буй агуу адислалуудын нэг билээ. Залбирлаар дамжуулан бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаж, өдөр бүр Түүнээс удирдамжийг авч болно. Залбирал нь бидний Тэнгэрлэг Эцэгтэй хийх чин сэтгэлийн ярилцлага юм.

Би та бүхэнтэй итгэл, гэрчлэлийг минь хүчирхэгжүүлсэн залбирлын талаарх хоёр туршлагаасаа хуваалцмаар байна.

1976 онд намайг 19 настай байхад систер номлогч нар сургаалыг надтай хуваалцсан юм. Номлогч нар бүх ярилцлагыг надад гурван сар гаруй заасны дараа тэд намайг сургаалын талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй болохыг уриалав. Мөн тэд надад баптисмын өдрөө товлон туслан, тэрхүү өдөрт сүнслэгээр бэлтгэж эхлэхийг хүсэв.

Баптисм хийлгэхээс долоо хоногийн өмнө би сүмд нэгдэн орох нь зөв гэж бодож байсан ч эцэг эхийн маань зөвшөөрөл хэрэгтэй байлаа. Харамсалтай нь миний эцэг эх, эмээ өвөө маань гэр бүлээрээ өдөр бүр өвөг эцгүүддээ зориулан тахил өргөдөг уламжлалтай байсан тул сүмд нэгдсэнийхээ дараа намайг гэр бүлийн тэрхүү жаягийг дагахгүй болно хэмээн тэд айж байлаа. Манай эмээ хамгийн ихээр эсэргүүцэж бүр надад сайн зааж чадсангүй хэмээн ээжийг минь зэмлэж байв. Хэрвээ би Сүмд нэгдэх юм бол эмээгээ насан эцэслэхээр түүний төлөө тахил өргөхгүй хэмээн эмээ маань эмээж байв. Мөн эмээ минь намайг харийн хүмүүсээр мэхлэгдэн



Далын Ахлагч
Сью Хонг Пон

Америк руу алтны уурхайд ажиллахаар явсан олон Хятад хүмүүсийн адил номлогч нарт мэхлэгдсэн гэж бодож байлаа. Хэдийгээр би Сүмийн талаарх өөрийн сэтгэлийг хуваалцахыг хамаг чадлаараа хичээж байсан боловч эмээд зэмлүүлсэн эцэг эх маань намайг дуулгаваргүй байна хэмээн Сүмд нэгдэхийг минь зөвшөөрөхгүй байв. Эцэг эхийгээ ятгаж чадахгүй нь гэдгээ ойлгон, тэдэнтэй маргалдахаас зайлсхийн, арга мухардан би өрөөндөө орлоо.

Маргааш нь сургуулиасаа тарж ирээд эцэг эхийнхээ зөвшөөрлийг авч чадаагүйдээ сэтгэл минь зовнисоор байлаа. Өрөөндөө ороод би арга зам байгаа эсэхийг бодохыг

хичээлээ. Тунгаан бодох зуураа би залбирлын талаар итгэлтэйгээр залбирвал Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонсох болно! хэмээн заасныг санаж өвдөг сөгдөн даруухнаар атлаа хичээнгүйгээр Тэнгэрлэг Эцэгт хандан Ариун Сүнсээ илгээн эцэг эхийг минь ятгаж өгөөч хэмээн залбирлаа. Би залбирлынхаа дараа тайван дулаан мэдрэмж зүрх сэтгэлд минь мэдрэгдэх хүртэл өвдөг сөгдөн суусаар байлаа. Түүний дараа би ээж дээрээ очоод хүндэтгэлтэйгээр Сүмийн талаарх өөрийн бодлоо хуваалцсан. Сургаалын ачаар би илүү сайн хүү байх болно гэж ээждээ хэлэв. Энэ удаад ээж маань намайг зэмлэсэнгүй, харин ааваасаа зөвшөөрөл авах хэрэгтэй гэв. Би ээжээсээ намайг Сүмд нэгдэхийг зөвшөөрч байгаа эсэхийг асуухад тэрээр үгүйсгээгүй.

Би тэр даруй аав руугаа очоод түүнтэй Сүмийн талаар болон сүмд өөрийн нэгдэх хүслийнхээ тухай ярилцах үед түүний хандлага

энэ удаад бас ээжийн адил өөр байсанд би итгэж ч чадахгүй байлаа. Тэрээр надад ээжийнхээ зөвшөөрлийг ав гэж хариулав. Би түүнд аль хэдийнэ ээжийнхээ зөвшөөрлийг авсан болохоо хэлээд түүний зөвшөөрлийг авах хэрэгтэй байснаа хэллээ. Аав маань хэсэг зуур бодсоноо намайг нас биед хүрсэн учир хэрэв Сүмд нэгдэх нь амьдралд чинь тус болно хэмээн бодож нэгдэхээр шийдвэл хориглохгүй хэмээв. Ганц өдрийн дотор ямар их өөрчлөлт гарав аа! Би юуг өөрөөр хийсэн болохоо тунгаан бодоод Тэнгэрлэг Эцэг миний залбиралд хариулжээ гэдэгт баттай итгэсэн. Ариун Сүнс эцэг эхийн маань зүрх сэтгэлийг зөөллөхөд тусалсан байлаа. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсдог, ялангуяа бид зөв шударга хүслээр зөв зүйлсийг асуувал үнэхээр сонсдог гэсэн гэрчлэлийг энэхүү үйл явдал надад өгч билээ.

Хоёр дахь туршлага нь олон жилийн өмнө намайг бишопоор үйлчилж байхад тохиолдсон юм. Нэгэн бямба гарагт би тойргийнхоо ганц бие эгчээс түүний амьдралын чухал шийдвэрт нь яаралтай туслах хүсэлтийг утсаар хүлээн авав. Тэр эгч манайхаас холгүй амьдардаг тул гэрт маань даруйхан ирлээ. Найзынхаа АНУ-аас айлчлан ирсэн ахтай нь болзож байгаагаар тэрбээр надад хэлэв. Хоёр өдөр болсоны дараа тэр хүн нь түүнд гэрлэх хүсэлт тавьжээ. Тэр Америк руу буцахаасаа өмнө түүний зөвшөөрлийг аваад бусад жижиг зүйлийг нь дараа шийдвэрлэхийг хүссэн байв. Тэр ах маргааш өдөр нь гэр рүүгээ харихаар төлөвлөсөн байсан тул тэр эгч түүнтэй гэрлэх эсэхээ шийдэж чадахгүй надаас зөвлөгөө авахыг хүссэн байв. Би тэр эгчийн ирээдүйг шийдвэрлэх зөвлөгөөг хэрхэн өгөхөө мэдэхгүй гайхширч байлаа.

Би түүнтэй өөрийн нөхцөл байдлаа сайн ойлгоход нь туслахын тулд түүнд болон түүний гэр бүлд тохиолдож болох үр дагавар, асуудлуудын талаар ярилцав. Түүний дараа би түүнд хэсэг тунгаан бодох хэрэгтэй байгаагаар хэллээ. Хэдийгээр түүний өмнөөс хариулт авахыг хүсээгүй ч тэрээр юу хийх хэрэгтэйгээ мэдэхийг

хүсч байгааг мэдэж байсан тул би түүнийг өөртэйгээ хамт Тэнгэрлэг Эцэгээс удирдамж эрэлхийлэн залбирахыг хүсэв. Бид удирдамж авахаар өвдөг сөгдөн даруухнаар залбирлаа. Би залбирлын дараа босолгүйгээр оюун бодолд минь ямар хариу ирэхийг анхааралтай чагнасан. Би хариултаа авсан. Гэсэн хэдий ч энэ хариулт тэрхүү эгчид маш чухал байсан тул би зүрх сэтгэлдээ хариултаа бататгахыг хүсэн дахин ганцаараа залбирлаа. Мөн би Тэнгэрлэг Эцэгээс тэр эгчид өөртэй минь адил мэдрэмжийг төрүүлж өгөөч гэж залбирсан билээ. Хоёр дахь удаагаа би урьдын адил хариултыг хүлээн авав. Хэсэг хугацааны дараа бид хоёул босоход тэр эгч над руу хариултаа хүлээн харж байв. Би өөрийн хүлээн авсан хариултаа хэлэлгүй харин түүнээс залбирлаас юу мэдэрсэн болохыг нь асуув. Тэрээр хэлэхдээ тэр ахтай гэрлэж болно гэсэн хариулт авсан ба энэ хариулт нь зөв эсэхэд итгэлтэй биш байна гэлээ. Би мөн түүнтэй адил хариултыг авсан байв.

Түүнтэй адилхан хариулт авсан гэдгээ хэлэхийн оронд би түүнийг өөрийн хүлээн авсан залбирлын хариуд итгэх хэрэгтэй хэмээн урамшуулсан. Цаашлаад би түүнд үүний адил амьдралдаа чухал шийдвэр гаргахдаа итгэлээ ашиглах хэрэгтэйг зөвлөсөн. Жилийн дараа тэрхүү ах эгч хоёр маань ариун сүмд гэрлэн аз жаргалтай гэр бүл болсон. Энэ тохиолдол надад зөвхөн өөрсдийн төлөө бус бусдын төлөө бид залбирч болох ба бүгд Тэнгэрлэг Эцэгээсээ хариулт авч болохыг ойлгоход минь тусласан.

Мосе 5:8-аас бид Их Эзний тэнгэр элч Адам Ева хоёрт наманчлан мөн Хүүгийн нэрээр Бурханд хандан залбирахыг тушаасныг сурдаг. Эндээс бид залбирал нь дэлхийн эхлэлээс сургаалын чухал хэсэг байсаар ирснийг хардаг. Залбир хэмээх тушаал нь үүрд байсаар ирсэн. Есүс Христийн сургаалаар амьдран, үргэлж залбирч байвал бид баяр баясгалантай байх болно. Бүх бодол санаа, үг, үйлдлүүдээ залбирлаар удирдуулж Бурхантай ойр байцгаая. Есүс Христийн нэрээр, амен. ■

Сэтгүүлийн орон нутгийн редактор Н.Пүрэвсүрэн

Энэ он Монгол дахь сүмийн гишүүдийн хувьд онцгой жил болж буйг бид бүхэн мэдэж мөн мэдэрч олон сайхан үйл явдлуудын гэрч нар болсоор байна. Өнгөрсөн дөрвөн сард үргэлжилсэн олон үйл ажиллагаануудад оролцож, Улаанбаатар Номлолд үйлчилж байсан номлолын ерөнхийлөгч болоод бүрэн цагийн олон номлогчид Монгол Улсад айлчилж, бид хүчтэй сүнслэг өдөөлтүүдийг мэдрэн хуучны анд нартайгаа уулзан баясах боломжтой байлаа. Энэ бүхэн Есүс Христийн сайн мэдээ хүмүүний амьдралд зөвхөн сайн сайхан, аз жаргал, зөв шийдлүүдийн үндэс болж байдгийг харуулж байна. Энэ оныг дуустал үргэлжлэн явагдах үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож, өөрсдийн гэр бүлийн гишүүд болоод найз нөхдөө урин, Христийн амласан “амьд ус”-наас хамтдаа хүртэн, мөнхийн аз жаргалыг өргөнөөр түгээцгээе! ■

Уламжлалт цуглаан үргэлжлэн явагдсаар

2007-2010 оны хооронд Улаанбаатар Номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа Ерөнхийлөгч Андерсон ах бүрэн цагийн номлолоос бууж байгаа болон номлолын ажилдаа шинээр дуудагдсан номлогчдын галын дэргэдэх ярилцлагыг зохион байгуулж, байнга тэдний сүнслэг гэрчлэлүүдийг сонсож байх гайхамшигт боломжийг бий болгосон билээ. Үүнээс хойш энэ цуглаан уламжлал болон тогтож, гишүүд сүнсээр тэжээгдэх нэгэн сайхан үдэштэй болсон юм. 2013 оны 3-р сарын 14-ний орой бид гайхамшигтай 14 номлогчдын гэрчлэлийг сонслоо. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

2005 он. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь дэлхийн 160 гаруй улсын 13 сая орчим гишүүдтэй дэлхий дахины байгууллага мөн бөгөөд Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын Төр, Сүм Хийдийн Харилцааны тухай хуулийн дагуу 1994 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 1040448 тоот регистрээр Улсын бүртгэлд бүртгэгдэж, дугаар 13 тоот Гэрчилгээг Хууль Зүйн Яамнаас олгогдсоны дагуу Монгол Улсад албан ёсоор байгуулагдсан байна. Энэ онд Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Улаанбаатар, Налайх, Баянзүрх, Орхон, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Зүүн-Хараа, Чойбалсан, Ховд, Мөрөн зэрэг аймаг хотуудад хоёр дүүрэг, 19 салбар нэгжийн удирдлагаар зохион байгуулагдан ажиллаж байв. Сүмийн гишүүдийн тоо 6500 гаруй болж, Есүс Христийн сайн мэдээг номлосон номлогчдын тоо 700 гаруйд хүрчээ.

Эрдэнэт, Чойбалсан, Сонгино салбарын цуглааны байрууд ашиглалтанд орж, албан ёсны нээлтийг 5 ба 6 саруудад хийж, үйл ажиллагаанд орон нутаг ба СХД-ээс төрийн болон төрийн бус байгууллагын

албанаас нийт 5000 орчим хүн урилгаар оролцсон байна.

2005.01.15. Гурван салбарын ХҮГ Залуу Эрэгтэйчүүд болон Залуу Эмэгтэйчүүдийн цугларалт Төв Байранд болсон байна.

2005.05.07. Дархан дүүргийн Дархан 1, Дархан 2 салбарын Залуу Эрэгтэйчүүдээс бүрдсэн скаут гишүүдийн санаачлагаар Сүмийн байранд зохион байгуулсан “Зөвийг Сонго” гэсэн уриатай “Дэлхийн хөгжлийн хотхон” сэдэвт үйл ажиллагаанд 2 салбарын 200 орчим гишүүд, сонирхогчид мөн бүрэн цагийн залуу болон ахмад номлогчид оролцжээ. Энэ шинэ сэдэвтэй өргөн арга хэмжээний үр өгөөж нь арвин болохыг гэрчилсэн оролцогчид сэтгэгдлээ бичиж үлдээсэн аж. Мөн Сүмд ирж байгаагүй болон сургаалыг сонирхсон олон оролцогчид энэ үйл ажиллагаанд оролцож улмаар сайн мэдээг сонсож зөв сонголт хийх анхны алхама хийхэд нь тусалсандаа “Дэлхийн хөгжлийн хотхон”-ы багийнхан баяртай байсан.

2005.05.12. Үйлчлэлийн цаг: Сэлэнгэ салбарын НХ-ийн эгч

нар Баяжуулалтын үдшийн цуглаанаар Сүмийнхээ байрны орчмыг тохижуулан цэцэгжүүлж, харин санваартан ах нар Сүмийн гишүүн нэгэн гэр бүлийнхэнд тусалж ногооны талбайн хөрсийг тариалах ажилд нь бэлтгэж өгчээ. Уг үйлчлэлийн өдөр гишүүд Сүхбаатар хотынхоо Нэгдсэн Эмнэлгийн гадаад орчинг тохижуулан цэцгийн үр суулгаж өгсөнд эмнэлгийн дарга маш их талархам хамт олноороо цэцгийн мандалаа сайн тордож байхаар болжээ.

2005.05 сар. Азийн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Жон Б.Диксон Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Сонгино байрыг онцгойлон адисласан байна.

2005 оны хавар Дорнод аймагт гарсан “үхрийн шүлхий” өвчний улмаас хөл хоригдсон бүсийн хүмүүст зориулж хүнс болон ариун цэврийн хэрэгсэл илгээж тусалснаас гадна Сүмийн “Дезерет” Олон Улсын Энэрлийн Байгууллагын зүгээс бусад эд материалын тусалцаа үзүүлсэн байна.

2005.07 сар. АНУ-аас “Дезерет” ОУЭБ-ын шугамаар нүдний эмч Рожер Харригаар ахлуулсан эмч нарын баг Улаанбаатар, Дарханд ажиллаж, нийт 1500 хүнд үйлчилж, харааг нь шалгаж тогтоон шил тааруулж өгөх, мөн монгол эмч нартай хамтран

нүдний мэс заслыг хэд хэдэн удаа амжилттай гүйцэтгэж туршлага солилцсон байна. АНУ-ын иргэн, мэргэжлийн шүдний эмч Гровер Р.Хүүпс энэрлийн байгууллагын сайн дурын ажилтан бөгөөд насанд хүрээгүй хүүхдүүдийн хорих ангид айлчилж, 120 гаруй өсвөр насныханд шүд, амны хөндийн үзлэг хийж, эрүүл ахуйн зөвлөмж өгсөн байна. Гровер эмч, Улаанбаатар, Чойбалсан, Эрдэнэт, Дархан зэрэг хотын шүдний эмч нартай хамтран ажиллаж, мэргэжлийн зөвлөгөө өгөх, зарим нэрийн нарийн багаж төхөөрөмж хандивласан байна.

2005.09 сар. Сүхбаатарын талбайд болсон “Амны хөндийн эрүүл ахуйн өдөр”-т ЭМШУИС-ийн Захирлын урилгаар оролцож, хүн ардад амны хөндийн үзлэг хийж, амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө өгч мөн шүдний оо, сойз үнэгүй тарааж үйлчилсэн байна.

2005.11.05. Улаанбаатар Дүүргийн насанд хүрэгчдийн чуулган “Итгэл” сэдвээр чууллаа. Чуулганыг Номлолын Ерөнхийлөгч Брайнер ах тэргүүлж, Улаанбаатар Дүүргийн Ерөнхийлөгч Д.Ганболд ах удирдлаа.

2005.12.25. Бошиглогч Иосеф Смитийн төрсний 200 жилийн ойд зориулсан баярын хурлын ажиллагааг сансраас шууд дамжуулсан бичлэгийг Баянзүрх байранд гишүүдэд үзүүлжээ.

2005.6 сар. ЧД-ийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сүмийн барилга шаваа тавьжээ.

2005 онд олон төрлийн үйл ажиллагаануудыг зохион явуулсаны дотор амьдралын түвшин доогуур, өрх толгойлсон эхчүүд болон олон хүүхэдтэй гишүүдэд нийт 13.893.984 төгрөгний хоол хүнс, эм тариа, орон байрны төлбөр түрээс, цахилгаан дулаан зэрэг ахуйн хэрэгцээнд нь тусламж үзүүлжээ. Мөн “Дезерет” ОУЭБ-аар дамжуулан тэргэнцэр, өвөл зуны эрэгтэй эмэгтэй хүний хувцас болон хүүхдийн хувцас боодлоор нь, гутал, дулаан хөнжил, малгай ороолт, хүүхдийн өлгий, ариун цэврийн хэрэгсэл, хүнсний хэрэгцээнд хуурай сүү, наран цэцгийн тос, хатаасан жимс мөн хүнсний нөөцөө бэлтгэхэд зориулж тариалах ногооны үрийг олон өрхөд хувиарлан олгосон байна.

2006.01.01. Шинэ оны эхний өдөр Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд Их Эзэнийг хүндэтгэсэн Ариун Ёслолын Цуглаанаа явууллаа.

2006.01.08. Улаанбаатар Номлолын анхны Ерөнхийлөгч /1995-1997/, Азийн Бүсийн Дaлын Ерөнхийлөгч байсан Ричард Е.Кук ахын эрүүл мэндийн төлөөх залбирал хийцгээж, 2006 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр түүний эрүүл мэндийн төлөө гишүүд мацаг барив.

2006.03.25. “Бид бие биедээ хэрэгтэй” уриатайгаар эргэж ирсэн номлогчдын анхдугаар чуулган Баянзүрх байранд чууллаа.

2006.04.16. Энэ өдөр Их Эзэний Дахин Амилалтын Баяр буюу Улаан Өндөгний Баярын Өдрийг тохиолдуулан “Их Эзэний гар” тоглолт болж хөтөлбөрийг Ахлагч М.Айбек ах танилцууллаа. Тоглолтын удирдагч Нямаагийн Пүрэвсүрэн эгч “Их Эзэний гар” хөгжмийн хөтөлбөр тоглолтын түүхээс хуваалцжээ. Ахмад номлогч Ивон Хьюжли эгч энэ тоглолтын талаар 10 гаруй жил найруулан удирдан тоглуулж ирсэн тухай сонсоод эх орондоо тоглуулах хүсэл ундарч улмаар анхны тоглолт Хьюжли эгчийн удирдлагаар 2003 оны 11 дүгээр сард, мөн 2004 оны 10 дугаар сард дөрвөн удаа /монгол, англи хэл дээр/ тоглогдсон байна.

2006.05.13. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Чойбалсан салбарын нээлттэй өдөр болж, гишүүдийн үйлчлэл болон сонирхогчдын талархлаар дүүрэн байжээ.

2006.05.13. Сүмийн Боловсролын Системийн Институтын захирал Пүрэвсүрэн ах хичээлийн төгсөлтөнд зориулсан хөтөлбөрт үйл ажиллагаа зохион байгуулж, 2005-2006 оны Шашны Сургалтаар дөрвөн судар үзэж суралцсан гишүүдэд цаг зав гарган өөрсдийн сүнслэг боловсролд гэрэл гэгээ

нэмсэнд баяр хүргэв.

2006.05.15. Монголын анхны ахмад номлогчоор Нямаагийн Пүрэвсүрэн эгч Англи Улсын Манчестер хотын номлолын албанд үйлчлэхээр дуудагдлаа.

2006.05.27. Улаанбаатар Дүүргийн чуулган чуулж, Улаанбаатар Дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл шинэчлэн өөрчлөгджээ. Ерөнхийлөгч Даваасамбуугийн Ганболд ах олон жил хийсэн үйлчлэлийн ажлаа Дүүргийн шинэ Ерөнхийлөгч Очиржавын Одгэрэл ахад хүлээлгэн өгсөн байна. 1-р зөвлөх Намхайн Адъяаболд ах, 2-р зөвлөх Мархашханы Айбек ах, гүйцэтгэх нарийн бичгээр Батгэрэлийн Дамдин ах нар дуудагдаж, санхүүчээр Энхжаргал ах улиран ажиллахаар болжээ.

2006.06.04. Улаанбаатар Дүүргийн Хүүхдийн Хэсгээс “Гэр бүл ба эх үрс” сэдэвт үйл ажиллагаа зохион байгуулж, Ариунзул эгч гэр бүл нь Бурханаас өгөгдсөн агуу төлөвлөгөөний нэг бөгөөд гэр бүлд эцэг эх нь үр хүүхдээ хайр халамжид өсгөх үүрэгтэй тухай яриа өгсөн байна. Хөтөлбөрийн арга хэмжээнд Баянзүрх салбарын гишүүн Дашгэрэл эгч охин Э.Уянгын хамт, Сэлбэ салбарын гишүүн Н.Пүрэвсүрэн эгч охин Б.Уянгын хамт мөн Ундрэм эгч Айбек ах нар ганцаар болон хослон, Залуу өсвөр үеийнхний хамтлаг тус тус эхийн хайр, энэрлийн тухай дуу дуулцажээ.

Хөтөлөгч Тамир ах Тэргүүн Зөвлөлийн Захиас бичгийг уншиж, Ганзориг ах эхийн хайр халамжийн үлэмж чанар, үр хүүхдээ өсгөх нь үр жимсээр дүүрэн модтой адил хэмээн, Цэрэнням ах ахмад номлогчийн анх номлолд явсан түүхээс яриа өгч мөн хөгжмийн чуулга хөгжимдөж үйл ажиллагаа өндөрлөсөн байна. Уг үйл ажиллагаанд 350 гишүүд, сонирхогчид оролцсон байна.

2007.1 сар. Энэ онд Чингэлтэй болон Дархан салбаруудын байр шинээр баригдан албан ёсны нээлтээ хийж ашиглалтанд ороход бэлэн болсонтой холбогдуулан зохион байгуулалтын зарим өөрчлөлтүүд хийгдэж, Дархан-Уул аймагт Дархан 1 салбар, нийслэл хотод Сансар салбар нээгдэн үйл ажиллагаагаа эхлэн явуулах болжээ.

2007.04 сар. “Бурхан бяцхан зүйлээс агуу ажлыг эхлүүлдэг” Лиахона сэтгүүл энэ дугаараас эхлэн орон нутгийн мэдээний хэсэгтээ Монгол Улсад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм үүсэн байгуулагдсан талаар цуврал түүхийг нийтлэхээр болсон байна. Энэ нийтлэлүүдээ Монголын Сүмийн анхдагчдын нэг, анхны Монгол салбарын ерөнхийлөгч /1994-1995/, анхны Дүүргийн ерөнхийлөгчийн /1996-1999/ дуудлагат ажлыг хийж байсан Ахлагч Тогтохын Энхтүвшин ах болон түүний гэр бүлийн гишүүдийн сүмд хөрвүүлэгдсэн түүхээр

эхлэн бичигджээ. Лиахона сэтгүүл 2007 оны 4 дүгээр сарын дугаартаа Монголын Улаанбаатар Номлолын Бүрэн Цагийн Номлолын Дуудлага аван үйлчилж буй Номлогчдын овог нэр, үйлчлэх Номлолын хаяг болон фото зургийг нийтлүүлж эхэлсэн байна.

2007.04.20. Улаанбаатар Дүүргийн Ерөнхийлөгчийн Зөвлөл хуралдаж, Сүмийн түүх бичих түр хороог 13 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулав.

2007.05.19-20. Улаанбаатар Дүүргийн чуулган болов.

2007.05.25-26. Хавай дахь Бригам Янгийн Их Сургуулийн “Алохатай хоршин дууля” сайн дурын найрал дууны хамтлаг айлчлан тоглолт хийв. Тоглолт Хөгжим Бүжгийн Коллежийн оюутнуудтай хамтран Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрт эхэлж, дараагийн өдөр нь Улсын Драммын Эрдмийн Театрт бие даасан тоглолтоор өндөрлөсөн байна.

2007.05.29. Сүмийн Боловсролын Системийн Сургалтын 2006-2007 оны хичээлийн жилд Улаанбаатар Дүүргийн хэмжээнд семинарт – 106, институтэд – 142 суралцагч, Дархан дүүргийн хэмжээнд семинарт – 71, институтэд – 105 суралцагч хамрагдан амжилттай төгсжээ.

2007.06 сар. Сургаал ба Гэрээний 121:45-ыг уриагаа болгосон

Улаанбаатар Дүүргийн Залуучуудын чуулган чуулж, Ариун Сүнс болон үйлчлэлээр дүүрэн болж өнгөрлөө. Хоёр өдөр үргэлжилсэн Чуулганы үйл ажиллагаанд оролцсон залуучууд хэрхэн зөв сүнслэгээр болзох, Сүмийн дуулыг сүнслэг хэрэгцээгээ болгох, номлолын ажилдаа мөн Есүс Христийн хоёр дахь ирэлтэнд бэлтгэх олон сүнслэг сургалтын хамт англи хэлийг шамдан суралцах болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зэрэг сургалт явагдаж, өргөн мэдлэгийг удирдагч, багш нараасаа суралцсан байна. Чуулганы хамгийн онцлог үйл явдал болсон Сүмийн Баянзүрх байрыг иж бүрэн цэвэрлэж сүнслэгээр урамшсан залуучууд маань “Мормон тусламжийн гар” үйлчлэлийг улам өргөжүүлжээ.

2007.07 сар. Хөгжлийн бэрхшээлтэй хараагүй хүмүүст зориулсан “Цагаан таяг” төслийн хүрээнд 220 хүн хамрагдан замын хөдөлгөөнд оролцох мэргэжлийн сургалтанд суралцаж мөн хэрэглэх таяг хүлээн авцгаажээ.

2007.07.01. Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Ахлагч Уаллас Ф.Брайнер ах Систер Бонне Брайнер нар чөлөөлөгдөж шинэ Ерөнхийлөгчөөр Ахлагч Дуглас Аллен Андерсен ах Систер Жил Андерсен нар дуудагдаа.

2007.08.20-27. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч

Еарл С.Тинги ах, Тинги эгч нарын айлчлал.

2007.09.13-14. Салбаруудын чуулган чуулав.

2007.09.27-28. Улаанбаатар Номлолын болон Дүүргийн Чуулган чуулжээ.

2007.09.25-28. Сүмийн Боловсролын Системийн шашны сургалтууд эхэллээ.

2007.11-12 сар. Хөгжлийн бэрхшээлтэй 500 иргэдэд тэргэнцэр тараагдсан бөгөөд үргэлжлэн 2008 онд 750 тэргэнцэр тараахаар төлөвлөжээ.

2007.12.16. Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд гурамсан судартай танилцах Галын Дэргэдэх Ярилцлага болж гишүүд, сонирхогчид идэвхтэй оролцож мөн суралцжээ.

2007 онд Сүмийн Байрнуудын доторх болон гаднах гудамж талбайн цэвэрлэгээ улирал бүр тогтмол хийгджээ. Батсүмбэр дэх Асрамжийн газар, Амгалан дахь Хүүхдийн Асрамжийн Газарт тусламжаар ирсэн хүнсний болон ороолт, малгай, бээлий, дулаан хөнжил зэргээр тусалсан байна. Сүмийн гишүүд, гэр бүлүүдийг батжуулах үүднээс төрөл бүрийн үйл ажиллагаа тухайлбал, эмэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдэд хоол хийх, ногоо даршлах, оёдол, нэхмэлд сургах, зөв хоолох, хувийн ариун цэвэр, соёлтой

харилцаанд суралцах болон гэрийн аж ахуй, төсвийг хэрхэн үр ашигтай зарцуулах зэрэг сэдвээр сургалт, хичээлүүд, залуу эрэгтэйчүүдийн дунд хувь хүний нийгэмд эзлэх байр суурь, урлаг спорт болон скаутын зэрэг олон сургалт хүмүүжлийн ажил зохион байгуулжээ. Сүмийн Боловсролын Сангийн зээлээр дотоодын их, дээд сургуулиудад сүмийн 40 гаруй залуу гишүүд суралцсан байна.

2007.12.23. Бидний Аврагч Есүс Христийн мэндэлсний баярт зориулан “Христийн мэндэлсний баярын аялгуу” хэмээх Улаанбаатар Дүүргийн Найрал Дуучдын Онцгой галын дэргэдэх цуглаан зохион явуулаа.

2008.01.01. Эргэж ирсэн номлогчдын бүжгийн цэнгүүнээр нийт 120 гаруй эргэж ирсэн номлогчид болох ганц бие болон гэр бүлийн хосууд энэ үдэш өөрсдийн номлолын туршлагаа дурсахын хамт уянгалаг намуун хөгжмийн аянд хөл нийлүүлэн бүжиглэх гайхалтай уулзалт түүхэнд бичигдэн үддлээ.

2008.01.09. Сүмийн Боловсролын Системийн ахмад номлогч Майкл Т.Страуд түүний гэргий Маргарет Страуд нар 31-ээс дээш насны гишүүдэд “Насанд хүрэгчдэд зориулсан шашны анги” нэртэй институтын хичээлийг явуулж эхэлжээ.

2008.01.24. Шинэ оны галын дэргэдэх ярилцлага дүүргийн Залуу Эрэгтэйтэйчүүдийн ярилцлагаар

эхэллээ. Өсвөр насны /12-15, 16-17/ болон ганц бие залуучуудын /18-30/ стандарт үдэшлэг сар тутам зохиогдсон байна.

2008.01.31. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч, Бошиглогч, Үзмэрч Гордон Б.Хинкли ахын таалал төгссөн тухай эмгэнэлийн илэрхийлэлт болон удаах Бошиглогчийн дуудлагын мэдээллийн тухай Сүмийн албан мэдээ танилцуулагдав.

2008.02.16. Дэлхий даяарх удирдагчдын сургалт болов.

2008.03.29. Эргэж ирсэн номлогч нарын чуулган чуулж, 150 гишүүд оролцжээ. Ерөнхий Нийгмийн Халамжийн 166 жилийн ойн баярыг тэмдэглэв.

2008.04.05. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Улаанбаатар Номлол байгуулагдсаны 15 жилийн ойн баяраа угтаж, Зайсан толгойн орчны талбайг цэвэрлэх “Мормон тусламжийн гар” үйлчлэлийн ажилд гишүүд идэвхтэй оролцлоо.

2008.04.15. Тэртээ 15 жилийн өмнө энэ өдөр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл агсан Монгол орныг сайн мэдээний төлөө гайхамшигтайгаар зөгнөн хэлсэн адислалын хүчээр өнөөдөр Монголын Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

7000 гаруй гишүүдтэй болж, хоёр дүүрэг, 22 салбар нэгжтэй боллоо өргөжин хөгжжээ.

Монголын долоо дахь ХҮТ, 1993 оны 7 дугаар сарын 31-нд баптисм хүртэж байсан Алтангэрэлийн Цог ах Монголын анхны баптисм хүртсэн хүүхэд байсан бөгөөд мөн тэрээр анхны дикон юм.

2008.05.18. Азийн Бүсийн Ерөнхийлөгч Дарил Х.Гарн ах гэргий Ирин Гарны хамт Сэлбэ Салбарын Ариун Ёслолын Цуглааныг тэргүүлээ. Гарн эгч эхчүүдийн тухай, Гэр бүлийн тунхаг бичигт заасан эцэг эхчүүдийн үүргийн тухай мөн хүүхэд, өсвөр насны залуу үеийнхэндээ хэрхэн зааж сурган хүмүүжүүлэх тухай сонгодог яриа өгөөд эхчүүд, ээж нар минь өөрт өгөгдсөн нандин үүргээ ухамсарлан ойлгож явахыг захиад мөн эмэгтэйчүүд бид зөвхөн гэр бүлдээ ч биш дэлхий дахинд нөлөө үзүүлж чаддаг хэмээх гэрчлэлээ хуваалцлаа.

2008.05.22. Улаанбаатар Дүүргийн Нийгмийн Халамжийн Чуулган чуулав. Чуулганыг Азийн Бүсийн Ерөнхийлөгч Дарил Х.Гарн ах тэргүүлжээ. Чуулган “Гэр бүл сүмийн үндсэн нэгж” сэдвээр чуулж, Дүүргийн зөвлөлийн гишүүн Н.Адъяаболд ах, Сүхбаатар салбарын гишүүн Бадамханд эгч, Ахлагч Рожерт нар яриа өгөв. Мөн Андерсен эгч, Гарн эгч, Гарн ах нар сүнсэлэг гэрчлэл хуваалцав.

2008.05.24-25. Улаанбаатар Дүүргийн чуулган чуулав.

2008.06.07. Сүмийн Боловсролын Системийн Институт Семинарын төгсөлтийн галын дэргэдэх ярилцлага болж, 2007-2008 оны хичээлийн жилийн сургалтанд 276 хүн суралцаж, төгсөлтийн гэрчилгээгээ гардан авцгаажээ.

2008.06. Гурамсан судар монгол хэл дээр хэвлэгдлээ. Тэргүүн Зөвлөлөөс монгол хэл дээрх гурамсан судар нь Монголын Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн судрын мэдлэгт чухал ач холбогдолтой байх болно хэмээн үнэлсэн байна.

Хамгийн олон Номлогчидтой групп Номлолынхоо үйлчлэлд гарлаа. Монгол орны зах хязгаар бүрээс Номлолд үйлчлэхийг хүссэн 31 залуучууд өөрийн эх орон болон гадаад улс орнуудад үйлчлэхээр дуудагдажээ.

2008.08.14. Сүмийн Боловсролын Системийн шашны хичээлийн шинэ жилд 14-17 насныхны өглөөний семинар долоо хоногийн эхний 4 өдөр бүр нэг, нэг цагаар дөрвөн судраас, 18-31 насны гишүүдийн институтын хичээл Сургаал ба Гэрээ судраас тус тус суралцахыг зарлав.

2008.10.25-26. Улаанбаатар Дүүргийн Чуулган чуулав.

2008.11.01-02. Улаанбаатар Номлол ба Улаанбаатар Дүүргийн чуулган чуулав.

2008.12.21. Шинэ оны мэндчилгээнд зориулсан хөгжимт галын дэргэдэх ярилцлага болов.

Энэ онд Сүмийн Ажил эрхлэлтийн албанаас явуулсан 23 удаагийн сургалтанд нийт 300 хүн хамрагдаж, төгсөлтийн гэрчилгээ авснаас 232 нь энэхүү сургалтын дүнд ажилтай болжээ. Хөгжмийн болон англи хэлний сургалтууд амжилттай явагдсан байна. Мичиганы англи хэлний түвшин тогтоох шалгалтанд шалгуулж тэнцсэн 46 залуу гишүүд АНУ-ын Бригам Янгийн Хавай дахь Их Сургуульд суралцаж байна. Мөн Юта мужийн Юта Вилли Стэт Коллеж, Бригам Янгийн Айдохо дахь Их Сургуульд 108 орчим залуу гишүүд шамдан суралцаж байна. Сүмийн Боловсролын Сангийн хүрээнд эх орныхоо их, дээд сургуулиудад 23 орчим гишүүдийг зээлийн гэрээгээр суралцуулж байна. 100 гаруй залуу гишүүд Монгол, Америк, Орос, Украин, Япон, Англи болон Солонгос улс орнуудад номлолын ажилд үйлчилж байна.

Улаанбаатар Дүүргийн удирдлагаас ХҮТ-ийн хагас жил тутмын Ерөнхий Чуулганы хурлын үйл ажиллагааг цаг тухайд нь гишүүддээ хүргэжээ. Мөн Дүүргүүдийн хагас жил тутмын Чуулганы хуралдаандаа гишүүд идэвхтэй оролцож, Ерөнхий Эрх

Мэдэлтнүүдийнхээ үгийг сонсож мөн тэднийгээ дэмжин баталцгаажээ. Эдүгээ Монгол Улсад Хожмын Үеийн Гэгээнтэн ах эгч нар 7500 хүрсэн нь 20 салбар нэгжтэй, хоёр дүүрэгт хамрагдан улмаар Их Эзэний сайн мэдээнээс суралцах итгэгчдийн тоо өсөн нэмэгдсээр буй нь 15 жилийн өмнө Арванхоёр Төлөөлөгчийн нэг Ахлагч Нийл А.Максвелл ах Монгол орныг сайн мэдээний төлөө адислахдаа гайхамшигтайгаар зөгнөн хэлсэн үгс цаг мөч бүхэнд биелэлээ олсоор байна. ■

Багшийг хөгжүүлэх сургалт

Сүмийн хэмжээнд олон төрлийн сургалт, насны онцлогт тохирсон үйл ажиллагаанууд болон Христийн сайн мэдээгээр хамтдаа өсөн хөгжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн явуулсаар ирсэн билээ. Бид Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, Бурхантай баптисмын гэрээнд орох үедээ хүн бүр Түүний сургаалыг дагагч, сайн мэдээг номлогчид байхаар гэрээг хийдэг. Тиймээс сүмийн гишүүн бүр номлогчид, гишүүн бүр багш нар юм. Сүмийн Боловсролын Системийн семинар, институтын ангиудад хамрагдахаас гадна өөрсдийн дуудлагууд болоод үйлчлэлүүдээрээ дамжуулан өөрсдийгөө сайн мэдээнд өсгөн хөгжүүлэх нь гишүүн бүрийн үүрэг мөн. Үүний учир сүмийн хэмжээнд багш нар болоод удирдагчдыг хөгжүүлэх сургалт явагдсаар ирсэн бөгөөд энэ онд Баянзүрх байранд сар бүрийн эхний Бямба гарагийн 11 цагт “Багшийг хөгжүүлэх сургалт” тогтмол явагдаж байна. ■